

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.2, 3.3, 3.4 дэх хэсэг:

“3.2.Монгол Улсын Үндсэн хуулийг бүхэлд нь хянан үзэж шинээр батлахтай холбогдсон харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

3.3.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баримтлах бөгөөд уг хуульд зааснаас бусад харилцааг Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулна.

3.4.Тухайн жилийн төсвийн тухай хуулийг боловсруулахтай холбогдсон харилцааг Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар зохицуулах бөгөөд эдгээр хуульд зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.”

2/15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэг:

“15.8.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний боловсруулах хууль тогтоомжийн төслөөр зохицуулах нийгмийн харилцаа нь Засгийн газрын бусад гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.”

3/15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсэг:

“15.12.Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр үзэл баримтлалын төслийг боловсруулж батлах бөгөөд хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана.”

4/22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг:

“22.2.Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж хууль шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хууль тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлал тодорхойлно.”

5/33 дугаар зүйлийн 33.3, 33.4, 33.5, 33.6, 33.7, 33.8 дахь хэсэг:

“33.3.Хуулийн төсөлд дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэхдээ зүйл тус бүрт зохицуулалтыг тусгах болсон үндэслэл, шаардлага, зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай болон хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, ухагдахуунд тайлбар хийнэ.

33.4.Энэ хуулийн 33.3-т заасан хуулийн төсөлд дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэхдээ хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрт оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт, зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах, хүчингүй болсонд тооцох, хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах тохиолдол бүрт тайлбар хийнэ.

33.5.Энэ хуулийн 33.4-т заасан тайлбар нь дараах мэдээллийг агуулсан байна:

33.5.1.нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг, өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага;

33.5.2.хуулийн төсөлд зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай;

33.5.3.хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, ухагдахууны агуулга.

33.6.Энэ хуулийн 33.3, 33.4-т заасан тайлбарыг зүйл тус бүрээр багцлан хийнэ.

33.7.Энэ хуулийн 33.5.3-т заасан хуулийн төслийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад холбогдох хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримталж болно.

33.8.Хэрэг, маргааныг шүүх, арбитраар хянан шийдвэрлэж хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэхэд хуулийн төслийн танилцуулга болон хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх үеийн хуралдааны тэмдэглэлийг ашиглаж болно.”

6/34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэг:

“34.6.Улсын Их Хурлаар олон улсын гэрээг соёрхон баталсны дараа Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинээр батлах хуулийн төслийг энэ хуулийн 34.5-д заасан хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлж боловсруулна.”

7/38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг:

“38.4.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр боловсруулсан хууль тогтоомжийн төсөл болон энэ хуульд заасны дагуу судалсан судалгааны тайланг 60 хоногоос доошгүй хугацаанд эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулж олон нийтээс санал авна.”

8/46¹ дүгээр зүйл:

“46¹ дүгээр зүйл.Хуулийн албан бус орчуулга хийх

46¹.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулийн албан бус орчуулгын сан бүрдүүлж, хувийг эрх зүйн мэдээллийн албан ёсны цахим хуудсанд байршуулна.

46¹.2.Хууль санаачлагч өөрийн санаачлан Улсын Их Хурлаар батлуулсан хуулийн албан бус орчуулгыг хийх бөгөөд орчуулгын хувийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуулийг батлагдсан өдрөөс хойш 3 сарын дотор хүргүүлж, энэ хуулийн 46.1-д заасан санд оруулна.

46¹.3.Улсын Их Хурлаас худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр батлуулсан хуулийн албан бус орчуулгын хувийг хууль санаачлагч хуулийг батлагдсан өдрөөс хойш 3 сарын дотор Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, энэ хуулийн 46.1-д заасан санд оруулна.”

9/51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг:

“51.4.Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжийг бүтнээр нь, эсхүл зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.”

2 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “холбогдох” гэсний дараа “асуудал хариуцсан” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “гарах” гэсний дараа “болон хуулийн албан бус орчуулгын” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх заалтын “боловсруулах,” гэсний дараа “шинэчлэн найруулах,” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “саналыг” гэсний дараа “бичгээр” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “төслөө” гэсний дараа “түүний үзэл баримтлал, танилцуулга,” гэж, 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь заалтын “хуваах” гэсний дараа “ба хэрэв өгүүлбэрүүд нь агуулгын хувьд хоорондоо уялдаа холбоотой бол нэг хэсэгт тусгах” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “төслийн” гэсний дараа “товч” гэж, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “бичиг нь” гэсний дараа “төрийн” гэж, Наймдугаар бүлгийн гарчгийн “бүрдүүлэх” гэсний дараа “системчлэн ангилах,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:

“1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлах, хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг тогтоох, хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах замаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулж хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино.”

2/2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт:

“2.1.2.“хууль санаачлах эрх” гэж хууль санаачлагчаас хуулиар тогтоосон хүрээ, хязгаарын дотор тодорхой хууль гаргах тухай санал дэвшүүлж, энэ хуульд заасан шаардлагыг ханган боловсруулах, боловсруулсан хуулийн төслийг хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг;”

3/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1.Энэ хууль нь хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, олон нийтэд сурталчлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.”

4/5 дугаар зүйл:

“5 дугаар зүйл.Хууль тогтоомж санаачлах

5.1.Хууль санаачлагч тодорхой хууль гаргах тухай санал дэвшүүлэх тохиолдолд холбогдох хуулийн төслийг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

5.2.Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид уламжилна. Хууль санаачлагч уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно.

5.3.Хууль санаачлагч Улсын Их Хурлын тогтоолыг санаачилж болно. Хуульд заасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд холбогдох саналаа хууль санаачлагчид уламжилна.

5.4.Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагаж хууль санаачлахгүй.”

5/6 дугаар зүйл:

“6 дугаар зүйл.Хууль тогтоомж санаачлах эрхийн хүрээ, хязгаар

6.1.Монгол Улсын Ерөнхийлөгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар хууль санаачилна.

6.2.Улсын Их Хурлын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Улсын Их Хурлын гишүүн санаачилна.

6.3.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааны тухай тогтоолыг холбогдох Байнгын хорооны түвшинд Улсын Их Хурлын гишүүн санаачилж болно.

6.4.Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолд энэ хуулийн 5.3, 6.3 дахь хэсэг хамаарахгүй.

6.4.Засгийн газар санаачлан боловсруулахаар Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Засгийн газар санаачилна.

6.5.Эрүү, иргэн, захиргаа, зөрчил, гамшигийн удирдлага, газар өмчлөх, эзэмших, ашиглах, татвар, нийгмийн даатгал, боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулсан анхдагч, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Засгийн газар санаачилна.

6.6.Засгийн газрын санаачлах хуулийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд заасны дагуу, эсхүл Засгийн газрын даалгавраар зохих хүрээ, салбарын асуудлаар хариуцан боловсруулна.”

6/7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг:

“7.3.Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл энэ хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно.

7.4.Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулна.”

7/13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг:

“13.3.Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад хийнэ.”

8/15 дугаар зүйлийн 15.7.1 дэх заалт:

“15.7.1.эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцаа;”

9/20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг:

“20.4.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, зардлыг тооцсон тайлангийн хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.”

10/21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг:

“21.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, зардлыг тооцсон тайлангийн хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.”

11/22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:

“22.1.Хуулийн төсөл дараах төрөлтэй байна:

- 22.1.1.анхдагч хуулийн төсөл;
- 22.1.2.хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл;
- 22.1.3.хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- 22.1.4.хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.”

12/34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг:

“34.5.Олон улсын гэрээг соёрхон баталснаар Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай тохиолдолд энэ талаар хуулийн төслийн үзэл баримтлалд дурдаж, агуулгыг тодорхойлно.”

13/38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг:

“38.2.Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, зардлыг тооцсон тайланг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана.”

14/45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг:

“45.4.Хууль тогтоомжийг цахим хэлбэрээр Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн мэдээллийн санд байршуулна.”

15/51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг:

“51.1.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц байдлаар хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно.”

16/49 дүгээр зүйл:

“49 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх байгууллага

49.1.Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран хэрэгжүүлнэ.

49.2.Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

49.3.Энэ хуулийн 15.7.1-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэх/ хэрэгжүүлнэ.

49.4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх буюу хамтран ажиллаж болно.

49.5.Хүрээлэнгийн ажиллах журам, орон тооны хязгаарыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

49.6.Хүрээлэн энэ хуулийн 15.7.1-д зааснаас бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээ болон энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.4-т заасан судалгааг захиалгаар төлбөртэй хийж болно.

49.7.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.”

4 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “, түүнчлэн” гэснийг “болон” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтын “үүсч” гэснийг “үүсэж” гэж, мөн зүйлийн 14.2.4 дэх заалтын “хуульд” гэснийг “шинэчлэн найруулах,” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “асуудал” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.1 дэх заалтын “хуульд” гэснийг “хууль болон хууль зүйн бодлогод” гэж, мөн зүйлийн 21.10 дахь хэсгийн “санал, дүгнэлтийн төслийг” гэснийг “саналыг” гэж, мөн зүйлийн 21.11 дэх хэсгийн “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд 72 цагийн дотор саналаа” гэснийг “хууль тогтоомжийн төсөлд 72 цагийн дотор санал, дүгнэлтээ” гэж, мөн зүйлийн 21.12 дахь хэсгийн “саналаа” гэснийг “санал, дүгнэлтээ” гэж, мөн зүйлийн 21.13 дахь хэсгийн “эрх” гэснийг “хууль” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан” гэснийг “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр” гэж, 28 дугаар зүйлийн

28.2.4 дэх заалтын “нэг” гэснийг “цөөн” гэж, мөн зүйлийн 28.2.5 дахь заалтын “нэгтгэж болно” гэснийг “нэгтгэх” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “баримтлалтай” гэснийг “, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой” гэж, мөн зүйлийн 29.1.8 дахь заалтын “журам” гэснийг “журмыг тусгасан байх” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “Хэлний бодлогын зөвлөлийн” гэснийг “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалтын “хэлээрх” гэснийг “хэл дээрх” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “үүрэг бүхий холбогдох бусад” гэснийг “чиг үүрэг бүхий” гэж, мөн зүйлийн “товъёгийг” гэснийг “товъёогийг” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн” гэснийг “зардлыг тооцсон” гэж, мөн зүйлийн 40.1.10 дахь заалтын “товъёг” гэснийг “товъёог” гэж, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “системчлэх” гэснийг “системчлэн ангилах” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 29.1.11 дэх заалтыг 29.2, 29.3 29.4 дэх хэсэг гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “Төрийн захиргааны төв байгууллагын саналд тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурсан байна.” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгийн “төслийн үндэсний аюулгүй байдлын үүднээс” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.2.23 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 26, 50 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг